



БАТЛАВ

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.МӨРӨН

2019 оны ... дүгээр сарын ...

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ /2019 ОН/

2019 оны 01 дүгээр сарын 15

Улаанбаатар хот

№	Гүйцэтгэх ажлын чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн
1	2	3	4	5
Төрийн албан хаагчийн ажиллах нөхцлийг сайжруулах талаар				
1	Ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн албан хаагчдын ажил үүргийг тодорхой болгох, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх	Жилдээ	Албан үүргээ гүйцэтгэх тав тухтай орчин бүрэлдэж, ажлын үр дүн сайжрах	Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
2	Албан хаагчдын үйл ажиллагааг бодитой үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлтийг батлан, үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, үр чадварыг харгалзан зэрэг дэв, үр чадварын нэмэгдлийг нэмэгдүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэх	Жилдээ		Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
3	Албан хаагчийн амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ		Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
4	Албан хаагчийн ажлын байр, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах бичгийн хэрэгсэл, дүрэмт хувцас, холбооны болон бусад техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас,	Жилдээ		Санхүү, хангалт, үйлчилгээний газар

1	2	3	4	5
1	хэрэгсэл, цэвэрлэгээ үйлчилгээний материалаар хангах, хөдөлмөр хамгааллын болон бусад зааварчилгаа өгөх, сургалт явуулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	Албан үүргээ гүйцэтгэх тав тухтай орчин бүрэлдэж, ажлын үр дүн сайжрах	Санхүү, хангалт, үйлчилгээний газар
5	Албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны засвар үйлчилгээ, техник, тоног төхөөрөмж, бичиг хэрэгслийн талаар судалгаа гарган засвар, тохижилт болон техник хэрэгслээр хангах	Жилдээ	Албаны бэлэн байдлыг хангах	Санхүү, хангалт, үйлчилгээний газар
6	Эрхэлсэн ажилдаа идэвхи зүтгэл гаргаж, албан үүргээ үр дүнтэй биелүүлж амжилт гаргасан албан хаагчийг төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан болон холбогдох бусад цол, тэмдгээр шагнуулахаар тодорхойлох	Жилдээ	Албан хаагчийн ажлын үр дүн сайжрах, ажиллах урам зориг, эрмэлзлэл бий болгох	Захиргаа, удирдлагын газар
7	Албан хаагчдыг гадаад, дотоод болон мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх	Жилдээ		
8	Хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн харилцааг ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, аливаа дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах	Жилдээ	Албан хаагчид жендэрийн талаар зохих мэдлэг, мэдээлэлтэй болсон байна	Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
9	Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны соёл болон сэтгэл зүйн талаар сургалт зохион байгуулах	Жилдээ	Албан хаагчийн ёс зүй, харилцааны соёл сайжрах, стресс төрөх нь багасах	Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
10	Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу албан хаагчдад ээлжийн амралтыг заавал биеэр эдлүүлэх, ажлын шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй тохиолдолд заавал нөхөн амруулах бөгөөд зайлшгүй тохиолдолд мөнгөн урамшуулал олгох	Жилдээ	Албан хаагчид ээлжийн амралтыг биеэр эдэлсэн байх	Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
11	Шинээр гэр бүл болсон залуу албан хаагчдад дэмжлэг үзүүлэх	Жилдээ		Захиргаа, удирдлагын газар

1	2	3	4	5
12	Гэр болон ердийн галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс олгох ажлыг зохион байгуулах	Жилдээ	Төрийн алба хашиж буй нийгмийн гишүүний хувьд сэтгэл ханамжийн баталгаатай байх нөхцөл бүрдэх	Санхүү, хангалт, үйлчилгээний газар
13	Өрх толгойлсон ганц бие эцэг, эх, шинээр гэр бүл болсон болон хүүхэд төрүүлсэн гэр бүлд эд хөрөнгийн болон санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлэх	Жилдээ		Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
14	Хилийн боомт, орон нутаг дахь газарт ажиллаж байгаа ажилтанд 5 жил тутамд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгоход шаардагдах судалгааг гаргаж, зардлыг төсөвт суулгаж, олгох	Жилдээ	Хилийн боомт, орон нутагт дахь албанд томилогдон ажиллаж буй албан хаагчдын ханамжийн баталгаатай байх нөхцөл бүрдэх үр дүн сайжрах, ажиллах урам зориг, эрмэлз боло	Захиргаа, удирдлагын газар, хүний нөөц
15	Орон нутаг дахь газар, хилийн боомтод ажиллаж буй албан хаагчдын ажлын болон амьдрах байрны нөхцөлийг сайжруулах, шинээр амьдрах байртай болоход анхаарах	Жилдээ		Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс
16	Орон нутаг дахь газар, хилийн боомтыг автомашинаар хангах, парк шинэчлэлийг хийх	Жилдээ		Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс
Төрийн албан хаагчийн эрүүл мэндийг хамгаалах талаар				
17	Албан хаагчид байгууллагын эмчээр эрүүл мэндийн анхан шатны үзлэг, оношилгоо, эмчилгээг журмын дагуу хийлгэх	Жилдээ		
18	Албан хаагчийн эрүүл мэндэд анхаарч жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулан зардлыг нь байгууллага хариуцах, бие бялдраа чийрэгжүүлэхэд нь хөнгөлөлттэй үнэ, нөхцөл бололцоогоор хангах	Жилдээ	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх	Захиргаа, удирдлагын газар
19	Дотоодын рашаан сувилалд сувилуулах, амрах тохиолдолд ирэх, очих замын зардлыг автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож жилд 1 удаа олгох эсэхийг төсвийн боломжийг харгалзан шийдвэрлэх	Жилдээ		

1	2	3	4	5
20	Эрүүл аж төрөх ёс" сэдвийн хүрээнд нарийн мэргэжлийн эмчийг урьж, улиралд 1 удаа албан хаагчдад яриа, танилцуулга хийх			
21	Өвөл болон хаврын улиралд "амин дэм, витаминжуулалтын аян" тогтмол зохион байгуулж, албан хаагчдаа эрүүлжүүлэхэд анхааран ажиллах	Жилдээ	Албан хаагчдыг амин дэмээр хангаж ажиллах	Захиргаа, удирдлагын газар

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР